



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Хүүхэд харах үйлчилгээний талаар
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд харах үйлчилгээг 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс үргэлжлүүлж, 2-3 хүртэлх насны хүүхдийг хамруулсугай.

2. Хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, Нийслэлийн Боловсролын газрын дарга, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч нарт тус тус даалгасугай.

2.1. Хүүхэд харагч нарт эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналт, хүүхдийн байгууллагатай хамтран халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.2. Хүүхэд харах үйлчилгээ эхлэхээс өмнө байр, орчинд ариутгал халдваргүйжүүлэлтийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэх;

2.3. Хүүхэд харах төвд ирэх, буцах замд хүүхэд, эцэг эх, хүүхэд харагч амны хаалт заавал хэрэглэх, төвд нэвтрэхэд биеийн халууныг тогтмол хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх арга хэмжээг хэвшүүлэх;

2.4. Хүүхдийг хоол, хүнсний хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх хяналтыг сайжруулах, эрүүл, шим тэжээллэг, аюулгүй хоол хүнсээр үйлчлэх;

2.5. Хүүхэд ханиалгах, халуурах, хоолой өвдөх, амьсгал давчдах зэрэг өвчний шинж тэмдэг илэрсэн үед анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх түр тусгаарлах өрөөг бэлтгэх;

2.6. Хүүхэд өөр хоорондоо аяга, халбага, тоглоом зэргийг дамжуулж хэрэглэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэх;

2.7. Ариун цэврийн өрөө, угаагуур, нүхэн жорлонд цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг холбогдох заавар, зөвлөмжийн дагуу тогтмол зохион байгуулах, гар халдваргүйжүүлэх уусмалыг шаардлагатай цэгүүдэд байршуулах;

2.8. Хүүхэд харах үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх холбогдох стандарт, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.9. Хүүхэд харах үйлчилгээний эрсдэлийн үнэлгээг эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөлтэй хамтран сар бүр зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.

3. 2020-2021 оны хичээлийн жилд Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн мэдээллийг Боловсролын удирдлага мэдээллийн системийн бүртгэлд давхцаж буй эсэхийг 2020 оны 10 дугаар сард багтаан хянах, хүүхэд харах үйлчилгээний статистик мэдээллийг

142010249

салбарын мэдээллийн системд оруулах ажлыг 2020 оны 12 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг Мэдээлэл технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/-т даалгасугай.

4. Хүүхэд харах үйлчилгээг цаашид улсын төсвийн бус хөрөнгийн эх үүсвэрт тулгуурлан хэрэгжүүлэх эрх зүйн орчин, хувилбарын судалгаа хийн, санал боловсруулж 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан танилцуулахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/-т даалгасугай.

5. Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах ажлыг удирдлагаар хангаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД  Л.ЦЭДЭВСҮРЭН